



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 4/132

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хөгжлийн бодлоготой уялдуулан орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутан, суралцах хүсэлтэй иргэнийг төрөлх нутагтаа суурьшин, ажиллаж амьдрах нөхцөлийг хангах, орон нутгаа гэсэн чин хүсэл эрмэлзэлтэй иргэдийг аймаг, сумын хөгжилд хувь нэмрээ оруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий "Төрөлх нутагтаа бид" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дор дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Дарга:	Засаг даргын орлогч	Г.Хэрлэнчулуун
Гишүүд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга	Ж.Гантулга
	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал	Г.Нямхатан
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга	Э.Мөнх-Эрдэнэ
	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга	С.Мөнхцэцэг
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн	Д.Өнөрцэцэг
Нарийн бичгийн дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	Г.Лхагвахатан

С1 631

2//.

2. Дээрх хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрт шаардагдах хөрөнгийг олон улсын байгууллага, хандивлагчдын зээл тусламж болон дотоод эх үүсвэрээс жил бүрийн Нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т даалгасугай.

3. Энэхүү дэд хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Г.Хэрлэнчулуун/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА